БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

## Баянцагаан сумын Цэцэрлэг 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Аудитын код:** БНА-2019/139/СТА-ТШЗ

Баянхонгор хот 2019 он


Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат

Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Цэцэгмаа

Утас: 88089024 Цахим хаяг: tsetsegmaadam@audit.gov.mn

Аудитор: Б.Цэрэнчимэд

Утас: 88302569 Цахим хаяг: tserenchimedb@sudit.gov.mn

Цахим хуудас: www.audit.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

# Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |

# Агуулга

1 Аудитын гэрчилгээ ... 3
2 Аудитын тайлан ... 5
2.1. Оршил ... 5
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага ... 5
2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт ... 6
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин ... 6
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ... 7
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал ... 7
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар ... 8
2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн ... 8
2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал ... 8
2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ... 8
2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ... 8
2.11. Шилэн дансны мэдээлэл ... 9
2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга ... 9
2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл ... 9
3 Аудит хийсэн санхүүгийн тайлан ... 10
3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ... 10
3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ... 10
3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ... 12
3.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан ... 13
3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ... 14

# 1 Аудитын гэрчилгээ

БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
64101 Номгон, Баянхонгор сум
Утас, факс 70-44-25-84
E-mail; bayankhongor@audit.gov.mn

БАЯНЦАГААН СУМЫН
ЦЭЦЭРЛЭГИЙН ЭРХЛЭГЧ
Ц.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

2019.02.25 № 2/72

танай __________ -ны №__________ -т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-т заасны дагуу Баянхонгор аймгийн Баянцагаан сумын Цэцэрлэгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Баянхонгор аймгийн Баянцагаан сумын Цэцэрлэгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Баянцагаан сумын Цэцэрлэгийн 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл,санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

D:\STA-2018\Баянцагаан сумын Цэцэрлэг\Тайлагнал\Аудитын гэрчилгээ.docx

2519125

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг хариуцлага**

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-т заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудитын хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Б.МӨНХБАТ

D:\STA-2018\Баянцагаан сумын Цэцэрлэг\Тайлагнал\Аудитын гэрчилгээ.docx

# 2 Аудитын тайлан

## 2.1. Оршил

Баянцагаан сумын Цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг  Эрхлэгч Ц.Өлзийсайханд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

## 2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Баянцагаан сумын Цэцэрлэгийн 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Баянцагаан сумын Цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 02 дугаар сарын 25-наас 2019 оны 02 дугаар сарын 25–ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2019 оны 02 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газрын аудитор Б.Цэрэнчимэд  хариуцаж хэрэгжүүлэв.

Баянцагаан сумын Цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Баянхонгор аймаг дахь төрийн аудитын газарт 2019 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 03 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

**2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

**2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин**

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Баянцагаан сумын Цэцэрлэгийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягтаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Баянцагаан сумын Цэцэрлэг нь “Хамран сургах тойргийн /2-5 нас/ сургуулийн өмнөх насны хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд бүрэн хамруулж сургалтыг хэрэгжүүлэхэд оршино” гэсэн эрхэм зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

Баянцагаан сумын Цэцэрлэг үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Баянцагаан сумын Цэцэрлэгийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гараагүй байна.

**2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газрын одоо мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг Сангийн яамнаас авч хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын шинэчлэлт, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцтэй байгаа эсэхийг судалж үзэхэд шинээр батлагдсан бодлого, журамд нийцэж байна.

Баянцагаан сумын Цэцэрлэгийн санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Баянцагаан сумын Цэцэрлэгийн санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн Санхүүгийн тооцоолох групп ХХК-ний "Acolous" программ хангамж ашигладаг байна.

**2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал**

Аудитын явцад Баянцагаан сумын Цэцэрлэгийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 1 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

**2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар**

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн тайлангийн нийт зардлын 2,0 хувиар сонгов.

Баянцагаан сумын Цэцэрлэгийн 2018 оны нийт зардлын дүн нь 327030,1 мянган төгрөг бөгөөд түүний 2,0 хувь болох 6540,6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг Б201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

**2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн**

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 4 чиглэлээр аудитын горим сорил гүйцэтгэж, аудитын явцад санхүүгийн тайланд алдаа зөрчил илрээгүй болно.

**2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал**

Аудитын явцад алдаа, зөрчил илрээгүй тул зөвлөмж, акт, албан шаардлага байхгүй болно.

**2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал**

Дараангийн аудитаар анхаарах асуудал илрээгүй

**2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Баянцагаан сумын Цэцэрлэгийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 2018 онд 308937,4 мянган төгрөгийн төсөв батлагдаж, үйл ажиллагаандаа 302435,1 мянган төгрөг зарцуулж, хэмнэгдсэн 6502,3 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

**2.11. Шилэн дансны мэдээлэл**

Баянцагаан сумын Цэцэрлэг нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

Тус байгууллага нь Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газраас хийсэн “Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудит”-аар Шилэн дансны хуулийн 6.1-д заасан мэдээллийн өөрт хамаарах 25 мэдээллийг хугацаанд нь, 6.4-д заасан мэдээллээс өөрт хамаарах 5,0 сая төгрөгөөс үнийн дүн бүхий орлогын 26 гүйлгээ байгааг хугацаанд тус тус мэдээлж хуулийн хэрэгжилтийг хангаж ажилласан байна.

**2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга**

Өмнөх оны санхүүгийн тайланд итгэл үзүүлж, аудит хийгээгүй байна

**2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл**

Бид Баянцагаан сумын Цэцэрлэгийн 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Баянцагаан сумын Цэцэрлэгийн 2018 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

# 3 Аудит хийсэн санхүүгийн тайлан

## 3.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **33,603,241.16** | **35,014,591.16** |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 33,603,241.16 | 35,014,591.16 |
| **351** | **Түүхий эд материал** | 17,892,528.40 | 18,284,678.40 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 17,892,528.40 | 18,284,678.40 |
| **354** | **Хангамжийн материал** | 15,710,712.76 | 16,729,912.76 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 350,200.00 | 350,200.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 13,736,812.76 | 15,362,812.76 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 180,000.00 | 00.00 |
| 35460 | Хүнсний материал | 446,800.00 | 00.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 996,900.00 | 1,016,900.00 |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **304,773,059.65** | **276,214,787.75** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 304,773,059.65 | 276,214,787.75 |
| **392** | **Биет хөрөнгө** | 304,773,059.65 | 268,082,787.75 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 345,136,206.00 | 250,602,188.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -58,426,501.10 | 00.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 21,265,113.00 | 22,875,113.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -17,856,280.94 | -19,628,781.09 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 40,327,498.95 | 40,730,698.95 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -27,811,582.86 | -31,799,224.55 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 381,200.00 | 6,981,806.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -190,600.20 | -3,627,019.36 |
| 39217 | Ном | 1,948,006.80 | 1,948,006.80 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | 00.00 | 8,132,000.00 |
| 39301 | Програм хангамж | 200,000.00 | 200,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -200,000.00 | -200,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 00.00 | 8,132,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **338,376,300.81** | **311,229,378.91** |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **338,376,300.81** | **311,229,378.91** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 338,376,300.81 | 311,229,378.91 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 393,245,027.83 | 401,377,027.83 |
| 51101 | Өмч: - төрийн | 393,245,027.83 | 401,377,027.83 |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | -118,941,585.42 | -160,439,293.32 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | -118,941,585.42 | -118,941,585.42 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -41,497,707.90 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 64,072,858.40 | 70,291,644.40 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **338,376,300.81** | **311,229,378.91** |

## 3.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|

| | | | |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **301,454,180.00** | **321,723,975.70** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **00.00** | **3,444,460.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 00.00 | 3,444,460.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 00.00 | 3,444,460.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 1,260.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 00.00 | 3,443,200.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,660,880.00** | **9,342,115.70** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 299,793,300.00 | 308,937,400.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 00.00 | 3,184,340.70 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 3,184,340.70 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 1,660,880.00 | 6,157,775.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 1,660,880.00 | 6,157,775.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **312,472,387.18** | **327,030,085.28** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **312,472,387.18** | **327,030,085.28** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 284,176,119.18 | 298,700,014.58 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 173,360,104.00 | 178,893,905.00 |
| 210101 | Үндсэн цалин | 160,057,809.00 | 159,942,254.00 |
| 210102 | Нэмэгдэл | 2,522,400.00 | 9,022,251.00 |
| 210104 | Урамшуулал | 5,151,666.00 | 9,929,400.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 5,628,229.00 | 00.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 20,500,066.00 | 21,692,748.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 13,602,585.00 | 14,509,126.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,864,098.00 | 1,799,793.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,342,237.00 | 1,439,365.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 335,556.00 | 358,896.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,355,590.00 | 3,585,568.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 13,319,817.00 | 18,986,672.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 880,866.00 | 1,254,373.00 |
| 210302 | Түлш, халаалт | 12,183,621.00 | 17,602,199.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 255,330.00 | 130,100.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 3,071,007.00 | 3,043,070.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 248,700.00 | 159,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 915,117.00 | 889,970.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,255,990.00 | 1,089,600.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 38,000.00 | 80,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 613,200.00 | 824,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 58,253,975.00 | 58,562,030.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 73,000.00 | 81,250.00 |
| 210502 | Хоол, хүнс | 58,180,975.00 | 58,084,930.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 395,850.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 00.00 | 669,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 00.00 | 669,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 140,000.00 | 164,100.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 140,000.00 | 164,100.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 410,500.00 | 1,854,890.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 410,500.00 | 1,854,890.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 15,120,650.18 | 14,833,099.58 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 169,500.00 | 2,604,240.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,060,643.00 | 298,200.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 13,890,507.18 | 11,930,659.58 |

| | | | |
|---|---|---|---|
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 28,296,268.00 | 28,330,070.70 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 28,039,606.00 | 21,827,775.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 1,660,880.00 | 6,157,775.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 20,253,726.00 | 15,195,600.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 6,125,000.00 | 474,400.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 256,662.00 | 00.70 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 256,662.00 | 00.70 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 6,502,295.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 6,502,295.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **-11,018,207.18** | **-5,306,109.58** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 00.00 | 36,191,598.32 |
| 225007 | Хөрөнгийн дахин үнэлгээний зардал | 00.00 | 36,191,598.32 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | 00.00 | -36,191,598.32 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **-11,018,207.18** | **-41,497,707.90** |

## 3.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **301,454,180.00** | **318,280,775.70** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **00.00** | **1,260.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 00.00 | 1,260.00 |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | 00.00 | 1,260.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 1,260.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **301,454,180.00** | **318,279,515.70** |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 299,793,300.00 | 308,937,400.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 00.00 | 3,184,340.70 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 3,184,340.70 |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 1,660,880.00 | 6,157,775.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 1,660,880.00 | 6,157,775.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **301,454,180.00** | **315,080,775.70** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **301,454,180.00** | **315,080,775.70** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **272,527,912.00** | **286,750,705.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 172,260,261.00 | 178,893,905.00 |
| 210101 | Үндсэн цалин | 153,743,881.00 | 159,942,254.00 |
| 210102 | Нэмэгдэл | 4,581,965.00 | 9,022,251.00 |
| 210104 | Урамшуулал | 7,348,817.00 | 9,929,400.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 6,585,598.00 | 00.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 20,969,909.00 | 21,692,748.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 17,239,104.00 | 14,509,126.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,048,108.00 | 1,799,793.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 735,663.00 | 1,439,365.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 172,072.00 | 358,896.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 1,774,962.00 | 3,585,568.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 12,618,867.00 | 19,002,672.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,586,866.00 | 1,254,373.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210302 | Түлш, халаалт | 10,702,871.00 | 17,422,199.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 329,130.00 | 326,100.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 3,086,757.00 | 3,007,070.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 173,700.00 | 159,500.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 1,127,067.00 | 889,970.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,049,990.00 | 1,089,600.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 38,000.00 | 80,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 698,000.00 | 788,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 61,200,775.00 | 58,507,380.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 73,000.00 | 81,250.00 |
| 210502 | Хоол, хүнс | 58,627,775.00 | 57,638,130.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,500,000.00 | 788,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 414,700.00 | 669,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 414,700.00 | 669,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 140,000.00 | 164,100.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 140,000.00 | 164,100.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 445,500.00 | 1,854,890.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 445,500.00 | 1,854,890.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 1,391,143.00 | 2,958,440.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 609,000.00 | 2,660,240.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 782,143.00 | 298,200.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **28,926,268.00** | **28,330,070.70** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 28,669,606.00 | 21,827,775.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 1,660,880.00 | 6,157,775.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 20,253,726.00 | 15,195,600.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 6,755,000.00 | 474,400.00 |
| **2133** | **Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 256,662.00 | 00.70 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 256,662.00 | 00.70 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 00.00 | 6,502,295.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 6,502,295.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **00.00** | **3,200,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **00.00** | **3,200,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **00.00** | **3,200,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 00.00 | 3,200,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 00.00 | 3,200,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **00.00** | **-3,200,000.00** |

## 3.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|
| **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **393,245,027.83** | **64,072,858.40** | **-118,941,585.42** | 338,376,300.81 |
| Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **393,245,027.83** | **64,072,858.40** | **-118,941,585.42** | 338,376,300.81 |
| Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 6,218,786.00 | 00.00 | 6,218,786.00 |
| Тайлант үеийн үр дүн | 8,132,000.00 | 00.00 | -41,497,707.90 | -33,365,707.90 |
| **2015 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **401,377,027.83** | **70,291,644.40** | **-160,439,293.32** | 311,229,378.91 |

## 3.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

| **Эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Тайлант оны** | |
|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 308,937,400.00 | 302,435,105.00 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 308,937,400.00 | 302,435,105.00 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 293,266,000.00 | 286,765,105.00 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 178,896,500.00 | 177,640,905.00 |
| 210101 | Үндсэн цалин | 161,197,300.00 | 159,942,254.00 |
| 210102 | Нэмэгдэл | 7,769,800.00 | 7,769,251.00 |
| 210104 | Урамшуулал | 9,929,400.00 | 9,929,400.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 00.00 | 00.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 21,733,400.00 | 21,355,748.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 14,661,700.00 | 14,284,126.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 1,771,700.00 | 1,771,693.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 1,416,900.00 | 1,416,865.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 353,200.00 | 353,196.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 3,529,900.00 | 3,529,868.00 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 21,204,800.00 | 19,002,672.00 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 1,639,400.00 | 1,254,373.00 |
| 210302 | Түлш, халаалт | 19,235,400.00 | 17,422,199.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 330,000.00 | 326,100.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 3,142,000.00 | 3,005,810.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 158,200.00 | 158,240.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 890,000.00 | 889,970.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,217,900.00 | 1,089,600.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 87,900.00 | 80,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 788,000.00 | 788,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 60,697,100.00 | 58,507,380.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 82,000.00 | 81,250.00 |
| 210502 | Хоол, хүнс | 59,827,100.00 | 57,638,130.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 788,000.00 | 788,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 3,869,500.00 | 3,869,500.00 |
| 210604 | Урсгал засвар | 3,869,500.00 | 3,869,500.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 164,100.00 | 164,100.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 164,100.00 | 164,100.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 598,400.00 | 260,550.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 598,400.00 | 260,550.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 2960200.00 | 2958440.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 2,662,000.00 | 2,660,240.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 298,200.00 | 298,200.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 15671400.00 | 15670000.00 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 15,671,400.00 | 15,670,000.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 00.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 15,195,600.00 | 15,195,600.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 475,800.00 | 474,400.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 308,937,400.00 | 302,435,105.00 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 308,937,400.00 | 302,435,105.00 |
| 131006 | Засгийн газрын тусгай сангаас санхүүжих | 00.00 | 00.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 308,937,400.00 | 302,435,105.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 23 | 22 |
| 620001 | Удирдах ажилтан | 01 | 01 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 14 | 15 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 08 | 06 |
| **63** | **СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР)** | 210 | 210 |
| **631** | **СУРГУУЛИЙН ӨМНӨХ БОЛОВСРОЛЫН БАЙГУУЛЛАГА** | 210 | 210 |
| 631001 | Төрийн өмчит СӨБ байгууллага | 210 | 210 |
| **65** | **ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ** | **22** | **22** |
| 650004 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 16 | 16 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 06 | 06 |
| 650010 | Гэрээт ажилтан | 00 | 00 |